

Дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг “Хөгжлийн бэрхшээл ба манлайлал дахь эмэгтэйчүүдийн судалгааны хүрээлэн”-ээс зохион байгуулж буй “WILD-2019” хөтөлбөрт урьж байна.

1. Хөтөлбөрийн товч танилцуулга:

Mobility International USA (MIUSA) нь жил бүр уг хөтөлбөрийг зохион байгуулдаг ба ойролцоогоор 25-н өөр орны, өөр соёлын эмэгтэйчүүдийн төлөөллийг хамруулан тэдний манлайлах чадварыг нэмэгдүүлэх, олон улсын оролцоог дэмжсэн хөгжлийн хөтөлбөрүүдийг дэмжих хүрээнд хамтын ажиллагаа, сүлжээ бий болгох, шинэ алсын хараа, бодлогыг тодорхойлох, зохион байгуулах зорилготой.

З-н долоо хоногийн хөтөлбөрийн хүрээнд оролцогчид олон улсын хөгжлийн хөтөлбөр дэх хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллын боломжийг дээшлүүлэх, нэмэгдүүлэх ажлын хэсэг, хэлэлцүүлэг, семинар болон багын ажиллагааг дэмжсэн үйл ажиллагаануудад хамрагдах юм.

2. Хугацаа

Уг хөтөлбөр нь 2019 оны 07 сарын 13-аас 08 сарын 3-ны өдрүүдэд АНУ-ын Орегон мужын Эугань хотод зохион байгуулагдана.

3. Хамрах хүрээ

1. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй байх
2. Дараах бүсүүдийн улс орны иргэн байх
 - Африк
 - Ази
 - Зүүн Европ
 - Кариб болон Латин Америк
 - Ойрх Дорнод
 - Номхон далайн орнууд
3. Ажил мэргэжлийн болон манлайллын хувьд:
 - 21 ба түүнээс дээш настай
 - Өмнө нь уг хөтөлбөрт хамрагдаж байгаагүй байх
4. Дараах хэлнүүдийн аль нэгийг эзэмшишсэн, хэрэглэдэг байх
 - Ярианы Англи хэл
 - Испани
 - Дохионы хэл /ярианы Америк дохионы хэл/

4. Тавигдах шаардлага

Уг хөтөлбөрт хамрагдахын тулд дараах шаадрлагуудыг хангасан байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй байх ба хөгжлийн бэрхшээлийн асуудлыг ойлгодог, бусад хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн эрхийн төлөө ажиллаж чадах;
- Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн асуудалд онцгойлон анхаардаг хөгжлийн бэрхшээлтэй хүнээр эсвэл эмэгтэйчүүдээр удирдуулсан байгууллагын эсвэл хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн эрхийг дэмжсэн иргэний нийгмийн байгууллагын гишүүн байх;
- Улс орон болон өөрийн нийгмийн бүлэгтээ хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх чадвар, үүрэгтэй байх;
- Олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд ХБ-тэй эмэгтэйчүүдийг оролцуулах чадвар, үүрэгтэй байх;
- Нэг жилийн хугацаанд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулах, гүйцэтгэх чадвартай байх. Үүнд:
 - Сургалтын хугацаанд хамтран ажиллах, үүрэг хүлээсэн байгууллагатайгаа харилцаа тогтоож, хөгжүүлсэн байх. Энэ нь таны төлөөлөх нэг байгууллага болон хамтын нийгмийн байгууллагыг багтаана;
 - WILD хөтөлбөр дууссанаас 4 сарын дараа уг хөтөлбөрийн арга барилыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан манлайллын ажлын хэсгийг удирдан чиглүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;
 - Манлайллын ажлын хэсэгт зориулсан жижиг хэмжээний тэтгэлэгт бүртгүүлэх, бүртгүүлэх үйл явцыг удирдах;
 - MIUSA (зохион байгуулагч) байгууллагаас шаардсан тайлан, үнэлгээний мэдээг цаг тухай бүрт хүргүүлэх;
 - MIUSA (зохион байгуулагч) болон бусад эрх баригчдад суралцсан хичээл болон сорилыг хуваалцах;

5. Хэл

- Уг хөтөлбөрийн албан ёсны хэл нь Америк дохионы хэл болон Англи болон Испани хэл
- Албан ёсны үйл ажиллагаа, ажлын хэсэг болон аяллууд дээр дохионы хэлний тайлбарлагч дагалдах болно.

6. Хөтөлбөрийн зардал

Оролцогчид дараах зардлыг хариуцна.

- Хөтөлбөрийн зардал нь 250 Америк доллар (2018 оны 11 сарын 12-ны өдрийн Монгол банкны ханшаар 641,000 төгрөг)
- Сургалтын тэтгэлэг нь тухайн хамрагдахыг хүссэн хүний санхүүгийн хэрэгцээ, боломжийг илэрхийлсэн үндэслэл дээр олгогдоно.

- АНУ-ын визний зардал
- Буудлын угаалгын зардал, батерэй, саван, шампунь, олон улсын ярианы кард
- Нэмэлт хоол болон хөнгөн зууш

MUSA-n (зохион байгуулагч) зүгээс дараах зардлуудыг хариуцна.

- АНУ-н B1/B2 визэнд ороход холбогдох бичиг баримтуудаар тусална.
- 2 талын аяллын тасалбарыг хариуцна. (Энгийн ангилал)
- Хөтөлбөр болон аяллын хугацаанд эрүүл мэндийн даатгалыг хариуцна.
- Хөтөлбөрийн хугацаанд дахь хоол болон байрлах байр, тээврийн хэрэгсэл
- Дохионы хэлний тайлбарлагч
- Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой хангамжууд. Тухайлбал дохионы хэлний тайлбарлагч, хувийн туслахын аяллын зардал гэх мэт

7. Хэрхэн бүртгүүлэх вэ?

1. Бүртгэлийн мэдээлэл (Өргөдөл)
2. Хөгжлийн бэрхшээлийн мэдээлэл
3. Мэргэжлийн туршлага
4. Эссэ бичих, асуултуудад хариулах
5. Өргөдөл гаргагч, оролцогчийг ажил, мэргэжил, чадварын хувьд манлайлагч гэдгийг тодорхойлох 2 хүний, байгууллагын тодорхойлолт (гэр бүлийн гишүүн байж болохгүй)
Жишээ нь: ажил олгогч, засгийн газар, агентлаг, ТББ гэх мэт

8. Бүртгэл дуусах хугацаа 2018 оны 11 сарын 30

Жич: Бүрэн гүйцэд бус материал хүлээн авахгүй.

Та бүртгүүлэхдээ <https://www.miusa.org/> хаягаар ороод “Call for applications: WILD 2019” дээр дарж бүртгүүлнэ үү.

9. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн өрөнхий газрын мэргэжилтэн Б.Цэвэлмаа

Утас: 7703-2222, 9921-8528